



Аудитын код: САГ-2018/790/СТА-ТХН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон
Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Аудитор Б.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaab@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын тооцооны талаар	4
2.9.2	Авлагын бүртгэлийн талаар	4
2.9.3	Авлагын үлдэгдлийн талаар	4
2.9.4	Бараа материалын зарцуулалтын талаар	4
2.9.5	Бараа материалын бүртгэлийн талаар	5
2.9.6	Үндсэн хөрөнгийн талаар.....	5
2.9.7	Санхүүжилтийн орлогын талаар	5
2.9.8	Төсвийн гүйцэтгэлийн талаар.....	5
2.9.9	Зардлын талаар	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал	8
3.1	Бараа материалын талаар	9
3.2	Бараа материалын бүртгэлийн талаар	10
3.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	11
3.4	Төсвийн гүйцэтгэлийн талаар.....	12
3.5	Зардлын талаар	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20

ЭМЯ, ГЛОБАЛЬ САНГИЙН
ДЭМЖЛЭГТЭЙ ДОХ-ЫН ТӨСЛИЙН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ ЭМЯ-НЫ САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНТУЯА
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн санхүүгийн тайланд

- Гадаадын байгууллагаас авах авлагаар тайлагнасан 75,647.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлагыг буруу тооцоолж бууруулсан,
- НҮБ-ийн хүүхдийн сангаас олгогдсон худалдан авалтын буцаалт 342,901.0 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- Батлагдсан төсвийг зарим бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулсан. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардлыг 367,277.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 69,313.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 21,353.1 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “оршин байх”, “эрх ба үүрэг”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн төсвийн шууд захирагч ЭМЯ-ны Санхүү, Эдийн засгийн хэлтсийн дарга Д.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, хөрөнгийн ашиглах, шилжүүлэх талаар шийдвэр гаргуулах, зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 8-наас 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, аудитор Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2018 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 18/029 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журам”, 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Төслийн зорилго: Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад харьяалагдах тус төсөл нь зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн ХДХВ, ДОХ, БЗДХ-ын эмчилгээ, тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар нийт хүн амыг ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, бага тархалтыг тогтоон барих үндсэн зорилготой байна.

Зорилтот бүлэг: Орон гэргүй сүрьеэтэй өвчтөнүүд, хоригдлууд, шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн амын бүлэг, алслагдсан нутгийн хүн ам, олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнүүд, ХДХВ-ийн халдвартай өвчтөнүүдэд илүү хүрч үйлчлэх.

Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

- ХДХВ, ДОХ, БЗДХ-ын тусламж, үйлчилгээний чанартай, ээлтэй орчин бүрдүүлсэнээр эрсдэлт бүлгийн хүн амын дунд ХДХВ-ын халдварын тархалтыг бууруулах,
- Нийт хүн ам болон өртөмхий бүлгийн хүн амын дунд ХДХВ-ийн халдвараас сэргийлэх хөтөлбөрийг өргөжүүлэх,
- ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- ХДХВ, ДОХ-ын хариу арга хэмжээнд олон салбарын оролцоог хангах, таатай орчинг бүрдүүлэх,
- Тандалтын тогтолцоог бэхжүүлэхийн тулд нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 22 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “винница” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжид дотоод хяналтын чиг үүрэг бүхий алба, нэгж байгуулаагүй байна. ЭМЯ-аас тайлант 2017 онд дотоод хяналт шалгалт хийгээгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Глобаль сангаар батлуулсан 2017 оны төсвийг Худалдаа хөгжлийн банк дахь долларын харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж нь 2017 онд Глобаль сангаас буцалтгүй тусламжийн санхүүжилт 2,625,736.1 мянган төгрөг, бусад орлого 255,408.6 мянган төгрөг, хүүгийн орлого 16,964.7 мянган төгрөг, нийт 2,898,109.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,211,091.9 мянган төгрөгийг зарцуулж ажилласан байна.

Мөн тус сангаас хандив тусламжаар 1,544,621.7 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах шаардлагатай мэдээллийг мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны цахим мэдээллийн санд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлага, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан байна. тайланг оруулсан байна. Тайлант онд Нийцлийн аудитын газраас шилэн дансны шалгалт орж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын тооцооны талаар

НҮБ-ийн хүүхдийн сангаас олгогдсон худалдан авалтын буцаалт 342,901.0 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.9.2 Авлагын бүртгэлийн талаар

Тайлант хугацаанд гадаадын байгууллагаас авах авлагыг 125,833.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн "оршин байх", "эрх ба үүрэг", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "үнэлгээ", "хэмжилт", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2.9.3 Авлагын үлдэгдлийн талаар

Гадаадын байгууллагаас авах авлага 75,647.9 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг буруу тооцоолж бууруулсан.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, авлагын тооцоог нийлж баталгаажуулах, авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгөв.

2.9.4 Бараа материалын зарцуулалтын талаар

Бараа материалын түүвэр тооллого хийхэд 16,246.6 мянган төгрөгийн үнэ бүхий буйдан, телевизор, зургийн аппарат зэрэг хөрөнгийг ЭМЯ-нд тушаал шийдвэргүйгээр хүлээлгэн өгч ашиглуулсан, хөрөнгө биетээр оршин байхгүй.

2017 оны эхний хагас жилээр 44,200.0 мянган төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулаагүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ..., аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах, хөрөнгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.5 Бараа материалын бүртгэлийн талаар

Салбар хүлээн авагчдад шилжүүлэх зорилготой бараа материалыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар тус төслийн нэгжид ашиглах шийдвэр гарсан боловч 10,400.0 мянган төгрөгийн үнэ бүхий тус хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, орлогод аваагүй. Аудитаар залруулах бичилт хийхдээ бараа материалыг дээрх дүнгээр илүү бууруулж тайлагнасан.

Худалдан авсан 10,500.0 мянган төгрөгийн бараа материалыг тухайн дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ..., аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.6 Үндсэн хөрөнгийн талаар

Тус төслийн нэгжийн балансад бүртгэлтэй Тоёота Ландкрузер-105, Ландкрузер вагон маркийн 92,420.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 2 ширхэг автомашин биетээр оршин байхгүй.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨТХ-ийг хэрэгжүүлж ажиллах, хөрөнгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.7 Санхүүжилтийн орлогын талаар

Худалдан авалтын буцаалтын 255,408.6 мянган төгрөг, нэр данс зөрүүгийн 11,487.2 мянган төгрөг, нийт 266,895.8 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлогыг илүү бүртгэж, тайлагнасан.

Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэл, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулав.

2.9.8 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр зарим зардал хэтрүүлсэн байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардлыг 367,277.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 69,313.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 21,353.1 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.9.9 Зардлын талаар

Мөнгөн хөрөнгийн журналаас түүврээр шалгахад төсвийг зориулалт бус зарцуулсан 33,919.5 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлан томилолтын хуудасгүй 15,445.4 мянган төгрөг, нийт 49,365.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Мөн завсрын аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу 106,700.0 мянган төгрөг, зориулалт бусаар 73,600.0 мянган төгрөг, нийт 180,300.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц дараах чухал асуудал байна. Үүнд:

Аудитын хугацаанд тус төслийн нэгжийн 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баримтыг ЭЦГ-ын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт шалгаж байгаагаас баримтыг үзэх боломжгүй байлаа.

Тус төслийн нэгжийн авлагын тооцоо, гадаад харилцагчаас ирүүлсэн бүртгэлээс зөрүүтэй байгаа бөгөөд залруулсан аудитын тайланг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас нарийвчлан шалгах боломжгүй байлаа.

Тайлант хугацаанд тус төслийн нэгжээс салбар харилцагч байгууллагуудад олгосон санхүүжилтийг батлагдсан төсөв болон нэхэмжлэхийн дагуу олгосон бөгөөд уг санхүүжилтээр 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны цар хүрээний хэмжээгээр тархмал тул эрсдлийн аудитаар гүйцэтгэлийг үзэх шаардлагатай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар тус төслийн нэгжийн гадаадын харилцагч байгууллагатай нийлсэн авлагын тооцоо, барагдуулалт, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнг зөв тайлагнах талаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,387,177.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 474,529.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 912,647.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанаас 418,548.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 513,198.9 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд 2017 оны эхний

хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сууриас 2 хувиар тооцож 44,830.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

- Гадаадын байгууллагаас авах авлагаар тайлагнасан 75,647.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, авлагыг буруу тооцоолж бууруулсан,
- НҮБ-ийн хүүхдийн сангаас олгогдсон худалдан авалтын буцаалт 342,901.0 мянган төгрөгийг тооцооны дансанд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- Батлагдсан төсвийг зарим бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулсан. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардлыг 367,277.7 мянган төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардлыг 69,313.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 21,353.1 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “оршин байх”, “эрх ба үүрэг”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 БАРАА МАТЕРИАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Бараа материалын түүвэр тооллого хийхэд 16,246.6 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг ЭМЯ-нд тушаал шийдвэргүйгээр хүлээлгэн өгч ашиглуулсан, хөрөнгө биетээр оршин байхгүй байна. 2017 оны эхний хагас жилээр 44,200.0 мянган төгрөгийн бараа материалыг тооллогод хамруулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ..., аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.1.1 "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, Санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

- НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.1.1-д заасныг тус тус мөрдөж ажиллах;
- Хөрөнгийн эзэмшлийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, данс бүртгэлд тусгах;
- Бараа материалын үлдэгдлийг хагас бүтэн жилээр тооллого хийж, баталгаажуулж ажиллах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.2 БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Салбар хүлээн авагчдад шилжүүлэх зорилготой бараа материалыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар тус төслийн нэгжид ашиглах шийдвэр гарсан боловч 10,400.0 мянган төгрөгийн үнэтэй хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, орлогод аваагүй. Аудитаар залруулах бичилт хийхдээ бараа материалыг дээрх дүнгээр илүү бууруулж тайлагнасан.

Худалдан авсан 10,500.0 мянган төгрөгийн бараа материалыг тухайн дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ..., аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлангийн "оршин байх", "тохиолдсон байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтуудыг тус тус мөрдөж ажиллах;
- Бараа материалын данснаас илүү бууруулсан бичилтийг залруулах;
- Бараа материалыг тооцооны дансаар дамжуулж бүртгэх;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус төслийн нэгжийн балансад бүртгэлтэй Тоёота Ландкрузер-105, Ландкрузер вагон маркийн 92,420.6 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 2 ширхэг автомашин биетээр оршин байхгүй.

Энэ нь ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно” заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

- ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтыг мөрдөж, хөрөнгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, данс бүртгэлд тусгах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.4 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт батлагдсан төсвийг хэтрүүлээгүй боловч бүлгийн дүнгээр зарим зардал хэтэрсэн байна. Тухайлбал: Бараа үйлчилгээний бусад зардал 367,277.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 69,313.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 21,353.1 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулах,

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" заалтыг хэрэгжүүлж ажиллах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.5 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн хөрөнгийн журналаас түүврээр шалгахад төсвийг зориулалт бус зарцуулсан 33,919.5 мянган төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлан томилолтын хуудасгүй 15,445.4 мянган төгрөг, нийт 49,365.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Мөн завсрын аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу 106,700.0 мянган төгрөг, зориулалт бусаар 73,600.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах,

ҮАГ-ын зөвлөмж

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллах;
- Төсвийн хөрөнгийн зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулах;

- Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Балансын үзүүлэлт	/ төгрөгөөр/	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,259,248,648.14</u>	<u>421,381,300.76</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,665,395,839.42	289,672,116.12
Гадаад валют	1,665,395,839.42	289,672,116.12
Арилжааны банк дахь харилцах	1,665,395,839.42	289,672,116.12
АВЛАГА	104,748,926.80	75,647,854.64
Бусад авлага	104,748,926.80	75,647,854.64
Байгууллагаас авах авлага	104,748,926.80	75,647,854.64
УРЬДЧИЛГАА	66,033,637.65	-
Урьдчилж гарсан зардал	66,033,637.65	-
БАРАА МАТЕРИАЛ	423,070,244.27	56,061,330.00
Хангамжийн материал	423,070,244.27	56,061,330.00
Бусад хангамжийн материал	423,070,244.27	56,061,330.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,289,817.74</u>	<u>51,307,847.04</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,289,817.74	51,307,847.04
Биет хөрөнгө	26,289,817.74	42,907,847.04
Авто-тээврийн хэрэгсэл	213,811,469.48	213,811,469.48
Хуримтлагдсан элэгдэл	(208,580,924.42)	(213,811,469.48)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,529,213.37	99,489,531.37
Хуримтлагдсан элэгдэл	(63,430,757.81)	(68,586,866.70)
Тавилга, аж ахуйн эд хогшил	38,251,017.97	40,618,459.97
Хуримтлагдсан элэгдэл	(25,290,200.85)	(28,613,277.60)
Биет бус хөрөнгө	-	8,400,000.00
Програм хангамж	-	8,400,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,285,538,465.88</u>	<u>472,689,147.80</u>
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,285,538,465.88</u>	<u>472,689,147.80</u>
Засгийн газрын хувь оролцоо	2,285,538,465.88	472,689,147.80
Хуримтлагдсан үр дүн	2,285,538,465.88	577,929,224.23
Өмнөх үеийн үр дүн	1,895,786,990.15	2,285,538,465.88
Тайлант үеийн үр дүн	389,751,475.73	(1,707,609,241.65)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	(105,240,076.43)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,285,538,465.88</u>	<u>472,689,147.80</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,937,726,530.66	4,080,133,513.42
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,937,726,530.66	4,080,133,513.42
Нийтлэг татварын бус орлого	2,572,116,170.86	2,909,596,603.64
Хүүгийн орлого	10,306,390.12	16,964,700.24
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,561,809,780.74	2,625,736,105.52
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,561,809,780.74	2,625,736,105.52
Бусад орлого		266,895,797.88
Тусламжийн орлого	365,610,359.80	1,170,536,909.78
Хандив тусламж /гадаад/	365,610,359.80	1,170,536,909.78
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,679,840,672.85	5,818,754,401.60
УРСГАЛ ЗАРДАЛ	2,679,840,672.85	5,818,754,401.60
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,679,840,672.85	5,818,754,401.60
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,010,076,035.29	1,246,832,886.00
Үндсэн цалин	1,010,076,035.29	1,246,832,886.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,291,367.20	281,676,157.35
Байрны түрээс	270,291,367.20	281,676,157.35
Хангамж, бараа материалын зардал	172,458,903.73	325,210,594.50
Бичиг хэрэг	-	7,422,211.00
Тээвэр, шатахуун	14,832,591.09	53,508,018.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,785,861.28	2,216,635.50
Ном, хэвлэл	154,840,451.36	255,147,048.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,916,682.00
Нормативт зардал	51,303,646.65	1,702,914,356.74
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,303,646.65	1,702,914,356.74
Эд хогшил, урсгал засварын зардал	22,054,197.00	6,163,627.00
Багаж, техник, хэрэгсэл	10,572,161.00	2,743,600.00
Тавилга	6,072,500.00	3,420,027.00
Урсгал засвар	5,409,536.00	-
Томилолт, зочны зардал	141,643,809.25	174,487,282.80
Гадаад албан томилолт	117,057,584.25	88,879,410.80
Дотоод албан томилолт	24,586,225.00	85,607,872.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	132,146,092.97	484,079,567.76
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,083,935.54	463,028,006.67
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	20,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,705,021.82	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,357,135.61	1,051,561.09
Бараа үйлчилгээний бусад зардал	879,866,620.76	1,597,389,929.45
Бараа үйлчилгээний бусад зардал	110,467,988.71	308,492,299.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	752,479,212.63	1,275,187,899.75
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,919,419.42	13,709,730.70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,257,194,438.95	(1,738,620,888.18)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	140,097,579.81	140,788,968.62

ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгжийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	140,097,579.81	140,788,968.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,231,961.89	109,777,322.09
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	8,231,961.89	109,777,322.09
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	131,865,617.92	31,011,646.53
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(7,125,328,821.03)</u>	<u>(1,707,609,241.65)</u>

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын капитал	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,895,786,990.15		1,895,786,990.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	389,751,475.73	-	389,751,475.73
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,285,538,465.88	-	2,285,538,465.88
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			(105,240,076.43)	(105,240,076.43)
Тайлант үеийн үр дүн	-	(1,707,609,241.65)		(1,707,609,241.65)
2017 оны 06-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	577,929,224.23	(105,240,076.43)	472,689,147.80

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,572,116,170.86</u>	<u>2,909,596,603.64</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,572,116,170.86	2,909,596,603.64
Нийтлэг татварын бус орлого	2,572,116,170.86	2,909,596,603.64
Хүүгийн орлого	10,306,390.12	16,964,700.24
Төсөв байгууллагын өөрийн орлого	2,561,809,780.74	2,625,736,105.52
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,561,809,780.74	2,625,736,105.52
Бусад орлого		266,895,797.88
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,813,902,296.70</u>	<u>4,211,091,897.04</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	2,813,902,296.70	4,211,091,897.04
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,813,902,296.70	4,211,091,897.04
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,010,076,035.29	1,246,832,886.00
Үндсэн цалин	1,010,076,035.29	1,246,832,886.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,291,367.20	281,676,157.35
Байрны түрээс	270,291,367.20	281,676,157.35
Хангамж, бараа материалын зардал	184,006,803.73	321,152,268.50
Бичиг хэрэг	-	7,367,711.00
Тээвэр, шатахуун	14,832,591.09	53,508,018.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,785,861.28	2,271,135.50
Ном, хэвлэл	166,388,351.36	251,143,722.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,861,682.00
Нормативт зардал	196,753,148.65	158,292,629.12
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	196,753,148.65	158,292,629.12
Эд хогшил, урсгал засварын зардал	32,561,011.27	102,797,744.45
Багаж, техник, хэрэгсэл	16,323,103.00	66,169,282.00
Тавилга	10,828,372.27	36,628,462.45
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,409,536.00	-
Томилолт, зочны зардал	147,712,559.25	174,487,282.80
Гадаад албан томилолт	117,057,584.25	88,879,410.80
Дотоод албан томилолт	30,654,975.00	85,607,872.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,443,472.97	475,232,313.72
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,381,315.54	454,180,752.63
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	20,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,705,021.82	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,357,135.61	1,051,561.09
Бараа үйлчилгээний бусад зардал	831,057,898.34	1,450,620,615.10
Бараа үйлчилгээний бусад зардал	107,402,712.71	303,988,446.48
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	723,655,185.63	1,146,632,168.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,161,334,814.90</u>	<u>(1,301,495,293.40)</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад эх үүсвэр	140,097,579.81	35,548,892.19

Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз	140,097,579.81	35,548,892.19
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	8,231,961.89	109,777,322.09
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус	8,231,961.89	109,777,322.09
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(131,865,617.92)</u>	<u>74,228,429.90</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)-(6)-(7)	(109,920,507.92)	(1,375,723,723.30)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,775,316,347.34	1,665,395,839.42
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,665,395,839.42	289,672,116.12

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,665,395,839.42		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,233,622,521.63	4,320,869,219.13	(87,246,697.50)	2.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,233,622,521.63	4,320,869,219.13	(87,246,697.50)	2.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,233,622,521.63	4,320,869,219.13	(87,246,697.50)	2.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,286,524,376.22	1,246,832,886.00	39,691,490.22	96.9
Үндсэн цалин	1,286,524,376.22	1,246,832,886.00	39,691,490.22	96.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	381,495,577.20	281,676,157.35	99,819,419.85	73.8
Гэрэл цахилгаан	-	-	-	
Байрны түрээс	381,495,577.20	281,676,157.35	99,819,419.85	73.8
Хангамж, бараа материалын зардал	299,799,160.72	321,152,268.50	(21,353,107.78)	7.1
Бичиг хэрэг	42,670,544.20	7,367,711.00	35,302,833.20	17.3
Тээвэр, шатахуун	17,924,616.00	53,508,018.00	(35,583,402.00)	198.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,683,108.20	2,271,135.50	37,411,972.70	5.7
Ном хэвлэл	199,520,892.32	251,143,722.00	(51,622,829.68)	25.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,861,682.00	(6,861,682.00)	
Нормативт зардал	499,944,925.07	158,292,629.12	341,652,295.95	31.7
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	489,210,071.71	158,292,629.12	330,917,442.59	32.4
Хоол, хүнс	10,734,853.36	-	10,734,853.36	-
Зөөлөн эдлэл, нормын хувцас	-	-	-	
Эд хогшил, урсгал засварын зардал	33,484,178.50	102,797,744.45	(69,313,565.95)	207.0
Багаж, техник хэрэгсэл	-	66,169,282.00	(66,169,282.00)	
Урсгал засвар	33,484,178.50	36,628,462.45	(3,144,283.95)	9.4
Томилолт, зочны зардал	174,028,105.12	174,487,282.80	(459,177.68)	100.3
Гадаад албан томилолт	133,993,973.19	88,879,410.80	45,114,562.39	(33.7)
Дотоод албан томилолт	40,034,131.93	85,607,872.00	(45,573,740.07)	113.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	475,003,281.13	475,232,313.72	(229,032.59)	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	446,373,686.13	454,180,752.63	(7,807,066.50)	1.7
Аудит баталгаажуулалт	28,629,595.00	20,000,000.00	8,629,595.00	69.9
Даатгалын үйлчилгээ	-	-	-	
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ		1,051,561.09	(1,051,561.09)	
Бараа үйлчилгээний бусад зардал	1,083,342,917.67	1,450,620,615.10	(367,277,697.43)	33.9
Бараа үйлчилгээний бусад	276,288,078.08	303,988,446.48	(27,700,368.40)	10.0

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	807,054,839.59	1,146,632,168.62	(339,577,329.03)	42.1
Бусад /Валютын ханшийн өөрчлөлт, бодит бус алд/		109,777,322.09	(109,777,322.09)	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,234,867,286.63	2,945,145,495.83	1,289,721,790.80	69.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,234,867,286.63	2,945,145,495.83	1,289,721,790.80	69.5
Глобаль сангаас санхүүжих	4,234,867,286.63	2,625,736,105.52	1,609,131,181.11	62.0
Хөрөнгийн санхүүжилт			-	
Бусад орлого		266,895,797.88	(266,895,797.88)	
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз		35,548,892.19	(35,548,892.19)	
Хүүгийн орлого		16,964,700.24	(16,964,700.24)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	289,672,116.12		